



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
УЛСЫН БАЙЦААГЧИЙН  
ДҮГНЭЛТ

2025 оны 02 дугаар сарын 07

Дугаар 0582

Улаанбаатар хот

Тамга, тэмдгийн хяналтын  
дугаар хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.7.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарг-ын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 14-д заасныг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Эко таун констракшн ХХК (5729661)-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Гантуяагийн гаргасан хүсэлтэд Эко таун констракшн ХХК нь тамга, тэмдгээ хаяж үрэгдүүлсэн тул хяналтын дугаар шинээр олгож өгнө үү.” гэсний дагуу мэдээллийн санд бүртгэлийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд Эко таун констракшн ХХК-нд 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдөл-УБ5 маягтад дарсан УНМ01873 дардасын тэмдэглэгээтэй, Монгол Улсын иргэн Э.Эрдэнэчулуун 100 хувийн хувьцаа эзэмшиж байна. Гүйцэтгэх удирдлагаар Э.Эрдэнэчулуун бүртгэлтэй байх бөгөөд өнөөдрийн байдлаар тус хуулийн этгээдэд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хоригийн бүртгэл бүртгэгдээгүй байна.

2.Эко таун констракшн ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Гантуяагийн гаргасан хүсэлт, түүнд хавсаргаж өгсөн нотлох баримтыг хянан үзэхэд: Чингэлтэй дүүргийн 13 хороо, Сургуулийн 42-909 тоот хаягт байршилтай, Эко таун констракшн ХХК-ийн тамга, тэмдгийн хяналтын УНМ01873 дугаартай тэмдгийг гээгдүүлсэн тухай 2025 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр, түүнд гүйцэтгэх захирал Э.Эрдэнэчулууны итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Гантуяагийн гарын үсэгтэй, 2025 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч С.Гантуяагийн гарын үсэгтэй хүсэлт, Нийслэлийн тойргийн нотариатч Д.Солонгын 2025 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн №0017 дугаартай Э.Эрдэнэчулууны С.Гантуяад “Тухайн компаний тамга тэмдэг захиалах, бичиг баримт бүрдүүлэх, хүсэлт гаргах, гарын үсэг зурах...” зэрэгт өөрийг нь бүрэн төлөөлж үйлдэл хийх эрхийг олгосон итгэмжлэл, (Итгэмжлэл нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд цахимжаагүй байсан тул нотариатч мэдээлэл хүргүүлж, цахимжуулсан болно.) хүчингүйд тооцсон тухай Өдрийн сонины 2025 оны 2 дугаар

1525030016

сарын 06-ны өдрийн №024(7636) дугаартай зар зэрэг нотлох баримтаар Эко таун констракшн ХХК нь тамга, тэмдгийн хяналтын УНМ01873 дугаартай тэмдгийг гэсэн болох нь нотлогдож байна.

3.Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Эко таун констракшн ХХК-ийг 500 нэгжээр торгож, энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 250 нэгжээр хөнгөрүүлж, торгож шийтгэл оногдуулсан тухай Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн 0838448 дугаартай шийтгэлийн хуудас байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1-т “Хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт “Тамга, тэмдэг устсан, түүнийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцож, хяналтын дугаарыг улсын бүртгэгч ажлын 2 өдрийн дотор дахин олгоно.” гэж заасныг тус тус баримтлан ДҮГНЭХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 5729661 регистрийн дугаартай Эко таун констракшн ХХК-д олгосон тамга, тэмдгийн хяналтын УНМ01873 дугаарыг хүчингүй болгох.

2.Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Эко таун констракшн ХХК-д мэдэгдэх.

3.Байгууллагын цахим сайтад байршуулах арга хэмжээ авах.

Дүгнэлтийн хувийг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлэх.

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  М.МӨНХГЭРЭЛ